**ГАЛТ ТЭРЭГНИЙ
ХӨДӨЛГӨӨН ЗОХИЦУУЛАЛТЫН
НЭГДСЭН ТӨВИЙН ЗАХИРЛЫН
ТУШААЛ**

2021 оны 01 сарын 22 өдөр | Дугаар А/09 | Улаанбаатар хот

2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө батлах тухай

Төрийн албаны тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.1, Засгийн газрын 2019 оны 37 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам"-ын 2.1, 2.6, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалын 3 дугаар хавсралтаар баталсан "Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах аргачлал", "Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төв" улсын төсөвт үйлдвэрийн газрын дүрмийн 6.9, Хөдөлмөрийн дотоод журмын 5.1.3-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "ГТХЗНТ" УТҮГ-ын 2021 оны Гүйцэтгэлийн төлөвлөгөөг хавсралтаар батлалсугай.

2. "ГТХЗНТ" УТҮГ-ын 2021 оны Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлж ажиллахыг Захиргаа, санхүүгийн хэлтэс, Тээврийн нэгдсэн удирдлага, автоматжуулалт, судалгааны хэлтэс, Гэрчилгээжүүлэлт, хөдлөх бүрэлдэхүүн ашиглалт, бүртгэл мэдээллийн хэлтэс /И.Банзрагч, Д.Төгсжаргал, Ц.Оюунбат/-т тус тус даалгасугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, санхүүгийн хэлтэс /И.Банзрагч/-т даалгасугай.

ЗАХИРАЛ А.БУЯННЭМЭХ

ТТБ5680 5670225

000775

“Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төв”
улсын төсөвт үйлдвэрийн газрын захирлын 2021 оны
01 дүгээр сарын 22-ны өдрийн А/09 дугаар тушаалын
хавсралт

# “ГАЛТ ТЭРЭГНИЙ ХӨДӨЛГӨӨН ЗОХИЦУУЛАЛТЫН НЭГДСЭН ТӨВ” УЛСЫН ТӨСӨВТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН 2021 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

| д/д | Хууль тогтоомж, бодлогын баримт бичиг | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хугацаа /улирал/ | Зорилтот түвшин | Хариуцах нэгж |
|---|---|---|---|---|---|---|---|
| **1.** | **Төмөр замын тээврийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3.1, 14.3.4, 14.3.5, 14.3.6, Төмөр замын техник ашиглалтын журмын 12.1.2, Галт тэрэгний хөдөлгөөний удирдлагын журмын 12.1, Галт тэрэгний зурмаг зохицуулалтын журмын 1.4, 1.6, 4.3, 6.1, 6.5, Төвийн дүрмийн 4.3.16, 4.3.17, 6.7.2.** | | | | | | |
| **1.1.** | **Галт тэрэгний хөдөлгөөний нэгдсэн зурмагийг баталж мөрдүүлэх, хэрэгжилтэнд хяналт тавих зорилтын хүрээнд:** | | | | | | |
| 1 | 1.1.1. Галт тэрэгний хөдөлгөөний 2021 оны зуны, 2021-2022 оны өвлийн цагийн хуваарийн нэгдсэн зурмаг боловсруулж батлах, гүйцэтгэлд хяналт тавих, тасалдалд дүн шинжилгээ хийх | --- | Тайлангийн тоо 18 | Хэрэгжүүлж байна | I | Галт тэрэгний хөдөлгөөний зурмаг тасалдлын 2020 оны XII болон IV улирлын, 2021 оны I, II сарын тайланг ЗТХЯ-нд танилцуулж, суурь бүтэц дэх хөдөлгөөний зурмагийн гүйцэтгэлд шинжилгээ хийсэн тайланд тусгагдсан санал зөвлөмжийн биелэлтийг тооцно | ТНУАСХ |
| | | | | | II | Зуны цагийн хуваарийн нэгдсэн зурмаг боловсруулж батална. Зурмаг тасалдлын III, IV, V сарын болон I улирлын тайланг ЗТХЯ-нд танилцуулна | |
| | | | | | III | Зурмаг тасалдлын VI, VII, VIII сарын болон II улирлын тайланг ЗТХЯ-нд танилцуулна. Суурь бүтэц дэх 2020-2021 оны өвлийн хөдөлгөөний зурмагийн гүйцэтгэлд ашиглалтын ажлын чанарын болон тоон үзүүлэлтээр дүн шинжилгээ хийж дүгнэлт, зөвлөмж гаргаж гүйцэтгэлийг сайжруулах албан даалгавар өгнө | |
| | | | | | IV | 2021-2022 оны өвлийн цагийн хуваарийн нэгдсэн зурмаг боловсруулж батална. Суурь бүтэц дэх хөдөлгөөний зурмагийн гүйцэтгэлд шинжилгээ хийсэн тайланд тусгагдсан санал зөвлөмжийн биелэлтийг тооцно. Зурмаг тасалдлын IX, X, XI сарын болон III улирлын тайланг ЗТХЯ-нд танилцуулна. Суурь бүтэц дэх хөдөлгөөний зуны зурмагийн гүйцэтгэлд | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ашиглалтын ажлын чанарын болон тоон үзүүлэлтээр дүн шинжилгээ хийж дүгнэлт, зөвлөмж гаргаж гүйцэтгэлийг сайжруулах албан даалгавар өгнө | |
| 2 | 1.1.2. Төмөр замын байгууллагын төлөөллийг оролцуулан зурмагийн хэрэгжилтийн дүнгийн хурал зохион байгуулах | --- | Дүнгийн хурлын тоо 4 | Шинээр хэрэгжүүлнэ | I<br>II<br>III<br>IV | Галт тэрэгний хөдөлгөөний удирдлагыг хэрэгжүүлэхэд чиглэсэн суурь бүтэц эзэмшигчийн үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангана | ТНУАСХ |
| 3 | 1.1.3. ЗТХЯ-ны ХШҮДАГ-тай хамтран суурь бүтэц дэх галт тэрэгний хөдөлгөөний зурмагийн биелэлтэд хяналт шалгалт хийх | --- | Хяналт, шалгалтын тоо 1 | Шинээр хэрэгжүүлнэ | III улирал | Тасалдалыг бууруулах, гүйцэтгэлийг сайжруулах албан даалгавар өгч биелэлтийг хангуулах, галт тэрэгний хөдөлгөөний удирдлагатай холбоотой санал, дүгнэлт гаргаж шийдвэрлүүлнэ | ТНУАСХ |
| **2. Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлогын 3.2.2.1, 3.2.4.5, төвийн дүрмийн 4.3.2.** | | | | | | | |
| **2.1. Шинээр бий болох суурь бүтцийг галт тэрэгний хөдөлгөөний удирдлага, зохицуулалтын нэгдсэн сүлжээнд холбох тооцоо, судалгаа боловсруулах зорилтын хүрээнд:** | | | | | | | |
| 4 | 2.1.1. Шинэ төмөр замын төсөл, хөтөлбөр болон техникийн баримт бичигт тусгах санал дүгнэлт гаргах | --- | Боловсруулалтын явц, хувиар | Хэрэгжүүлж байна | Тухай бүр | Санал, дүгнэлт боловсруулж ЗТХЯ-нд танилцуулна | ТНУАСХ<br>ГХБАБМХ<br>ЗСХ |
| **3. Төмөр замын тээврийн аюулгүй байдалтай холбоотой зарим обьект, үйл ажиллагаанд гэрчилгээ олгох журам, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2020 оны "Эрх шилжүүлэх тухай" А/81 дүгээр тушаал, "Төрийн зарим ажил, үйлчилгээг хариуцуулан гүйцэтгүүлэх тухай" гэрээ, Төвийн дүрмийн 4.2.2, 4.2.3.** | | | | | | | |
| **3.1. Төмөр замын тээврийн аюулгүй байдалтай холбоотой зарим обьект, үйл ажиллагааг гэрчилгээжүүлэх зорилтын хүрээнд:** | | | | | | | |
| 5 | 3.1.1. Төмөр замын тээврийн аюулгүй байдалтай холбоотой обьект, үйл ажиллагаанд гэрчилгээ олгох, хугацааг сунгах, нөхөн олгох талаар санал, дүгнэлт гаргаж шийдвэрлүүлэх, гэрчилгээжүүлэлтийн мэдээллийн сан бүрдүүлж хөтлөх, баяжуулах, холбогдох байгууллагыг мэдээллээр хангах үйл ажиллагааг эрх шилжүүлсний үндсэн дээр хэрэгжүүлэх | --- | ТЗТАБХЗОҮ АГОЖ-ын 4, 5, 6, 7 дугаар бүлэг болон тавигдах шаардлага | Хэрэгжүүлж байна | I-IV | Гэрчилгээжүүлэлтийн баримт бичгийн иж бүрдлийг нягтлан шалгаж гэрчилгээжүүлэлтийн нөхцөл шаардлага хангаж буй эсэхийг холбогдох журмын хүрээнд хянан, санал дүгнэлт, шийдвэрийн төслийг ЗТХЯ-нд уламжлан шийдвэрлүүлнэ | ГХБАБМХ |
| **4. Төмөр замын байгууллагууд харилцан мэдээлэл солилцох журам, Төвийн дүрмийн 4.2.1, 4.3.7.** | | | | | | | |
| **4.1. Төмөр замын тээврийн статистик мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх, хөтлөх, боловсруулах, дүн шинжилгээ хийх зорилтын хүрээнд:** | | | | | | | |
| 6 | 4.1.1. Төмөр замын тээврийн салбарын статистик мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх, хөтлөх, боловсруулах, дүн шинжилгээ хийх, танилцуулах | --- | Статистик мэдэээний тоо 4245 | Хэрэгжүүлж байна | I | Хоногийн 960, долоо хоногийн 48, сарын 27, улирлын 20, жилийн 25 мэдээг бүрдүүлж төвлөрүүлэн, ЗТХЯ, ҮСХ-г жилийн 25, улирлын 14, сарын 3 мэдээллээр хангана | ГХБАБМХ |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | II | Хоногийн 1920, долоо хоногийн 96 , сарын 54, улирлын 40, жилийн 25 мэдээгээр нэгдсэн санг бүрдүүлж, ЗТХЯ, ҮСХ-г жилийн 25, улирлын 28, сарын 6 мэдээллээр хангана | |
| | | | | | III | Хоногийн 960, долоо хоногийн 48, сарын 27, улирлын 20 мэдээг бүрдүүлж төвлөрүүлэн, ЗТХЯ, ҮСХ-г улирлын 14, сарын 3 мэдээллээр хангана | |
| | | | | | IV | Хоногийн 3840, долоо хоногийн 192, сарын 108, улирлын 80, жилийн 25 мэдээгээр нэгдсэн санг бүрдүүлж, ЗТХЯ, ҮСХ-г жилийн 25, улирлын 56, сарын 12 мэдээллээр хангана | |
| **5. Монгол Улсын хилээр нэвтэрч буй хөдлөх бүрэлдэхүүний бүртгэл хөтлөх, хүлээлцэх журам, Төвийн дүрмийн 4.3.11, 4.3.18.** | | | | | | | |
| **5.1. Монгол Улсын хилээр нэвтэрч буй хөдлөх бүрэлдэхүүний бүртгэл хөтлөх, хүлээлцэх журмыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах зорилтын хүрээнд:** | | | | | | | |
| 7 | 5.1.1. Монгол Улсын хилээр нэвтэрч буй хөдлөх бүрэлдэхүүнд шинээр дугаар олгох, баталгаажуулах, мэдээллийн санд бүртгэх, ЗТХЯ-ыг мэдээллээр хангах | 2.0 | Хүсэлт, албан бичгийн тоо, тэдгээрийн шийдвэрлэлт | Хэрэгжүүлж байна | I-IV | Хүсэлт, албан бичгийг хуулийн хугацаанд шийдвэрлэж, хөдлөх бүрэлдэхүүний мэдээллийн сан бүрдүүлж хөтлөн, ЗТХЯ-ыг мэдээллээр хангана | ГХБАБМХ |
| **6. Төвийн дүрмийн 4.3.3, 4.3.4.** | | | | | | | |
| **6.1. Салбарын эрх зүйн орчныг сайжруулах, боловсронгуй болгох ажилд дэмжлэг үзүүлэх зорилтын хүрээнд:** | | | | | | | |
| 8 | 6.1.1. Тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогч төмөр замын байгууллагуудын нэгдсэн технологийн горимын төслийг боловсруулж зохих журмын дагуу батлуулахаар хүргүүлэх | --- | Боловсруулалтын явц, хувиар | Төслийг боловсруулсан | I | Нэгдсэн технологийн горимын төслийг боловсруулна | ТНУАСХ |
| | | | | | II | Захиргааны ерөнхий хуулийн 61, 62 дугаар зүйлд заасны дагуу захиргааны хэм хэмжээний актын төслийг бэлтгэж, санал авна | |
| | | | | | III | Хэлэлцүүлэг зохион байгуулна | |
| | | | | | IV | Зохих журмын дагуу батлуулахаар ЗТХЯ-нд хүргүүлнэ | |
| 9 | 6.1.2. Төмөр замын тээвэрлэлттэй холбоотой ажил, үйлчилгээ, бүтээгдэхүүнд гэрчилгээ, тохирлын үнэлгээ, баталгаажуулалтыг олгох, сунгах, түтгэлзүүлэх, сэргээх журмын төсөл боловсруулах | --- | Боловсруулалтын явц, хувиар | Шинээр хэрэгжүүлнэ | I | Бусад салбарын тохирлын үнэлгээ болон гэрчилгээ олгох үйл ажиллагааг зохицуулсан эрх зүйн баримт бичигтэй танилцаж судална | ГХБАБМХ |
| | | | | | II | Захиргааны ерөнхий хуулийн 61, 62 дугаар зүйлд заасны дагуу захиргааны хэм хэмжээний актын төслийг боловсруулж санал авна | |
| | | | | | III | Төсөлд холбогдох саналыг тусган ЗТХЯ-нд хүргүүлнэ | |
| 10 | 6.1.3. Ачаа, зорчигч тээврийн вагон. бүтцийн бат бэх ба динамик гүйцэтгэлийг шалгах арга зүй ГОСТ | 3.0 | Боловсруулалтын явц, хувиар | Шинээр хэрэгжүүлнэ | I | Төслийг орчуулан боловсруулна | ГХБАБМХ |
| | | | | | II | Төсөлд салбарын байгууллагын саналыг тусгана | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 33788:2016 стандартыг орчуулан боловсруулах | | | | III | Төслийг мэргэшсэн, зөвлөх болон доктор (Ph.D) зэрэгтэй инженерээр хянуулна | |
| | | | | | IV | ТЗДАБУЗСТХ-гоор хэлэлцүүлж үндэсний стандартаар батлуулна | |
| 11 | 6.1.4. Нийлүүлэлтийн сүлжээний RFID хэрэглээ-ачааны чингэлэг, ачааны чингэлгийг автоматаар тодорхойлон таних систем ISO 17363:2007, Мэдээллийн технологи, удирдлагын радио давтамжийг ялган тодорхойлох таних тэмдэг ISO/IEC 29160:2012 стандартыг орчуулан боловсруулж батлуулах | 6.0 | Боловсруулалтын явц, хувиар | Орчуулж боловсруулсан | I | ТЗДАБУЗСТХ-гоор хэлэлцүүлж үндэсний стандартаар батлуулна | ГХБАБМХ |
| 12 | 6.1.5. Үндэсний MNS 6387-1:2013, MNS 6387-2:2013, MNS 6387-3:2013, MNS 6387-4:2013 стандартын нэр томьёог сайжруулан боловсруулж батлуулах | 6.0 | Боловсруулалтын явц, хувиар | Шинээр хэрэгжүүлнэ | I | Нэр томьёог боловсруулна | ГХБАБМХ |
| | | | | | II | Төсөлд салбарын байгууллагын саналыг тусгана | |
| | | | | | III | Төслийг мэргэшсэн, зөвлөх болон доктор (Ph.D) зэрэгтэй инженерээр хянуулна | |
| | | | | | IV | ТЗДАБУЗСТХ-гоор хэлэлцүүлж батлуулна | |
| 13 | 6.1.6. Галт тэрэгний хөдөлгөөний зурмаг боловсруулах журмын төсөл боловсруулах | --- | Боловсруулалтын явц, хувиар | Шинээр хэрэгжүүлнэ | I | Журмын төслийг шинээр боловсруулна | ТНУАСХ |
| | | | | | II | Төмөр замын байгууллагаас санал авна | |
| | | | | | III | Хэлэлцүүлэг зохион байгуулна | |
| | | | | | IV | Журмын төслийг ЗТХЯ-нд танилцуулна | |
| 14 | 6.1.7. Тохирлын үнэлгээний загвар баримт бичиг боловсруулах, гадаад орны тохирлын үнэлгээний байгууллагатай харилцаа тогтоож уулзалт танилцуулга зохион байгуулах, баталгаажуулалтын байгууллагыг бойжуулах гэрээг зохих байгууллагатай байгуулах | 18.0 | Боловсруулалтын явц, хувиар | Шинээр хэрэгжүүлнэ | I-II | Тохирлын үнэлгээний загвар баримт бичиг боловсруулна | ГХБАБМХ ТНУАСХ |
| | | | | | III-IV | Баталгаажуулалтын байгууллага болох бэлтгэлийг бүрэн хангана | |
| **7. Цахим засаглал үндэсний хөтөлбөр, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2020 оны “Цахим болон тоон гарын үсэгт шилжүүлэх тухай” А/160, “Ажлын хэсэг байгуулах тухай” А/213, Зам, тээврийн салбарын үйлчилгээ, үйл ажиллагааг цахимжуулах дунд хугацааны хөтөлбөр, Төвийн дүрмийн 4.3.10, 4.3.11, 4.3.12, “ГТХЗНТ” УТҮГ-ын захирлын 2021 оны А/01 дүгээр тушаал** | | | | | | | |
| **7.1. Цахим шилжилт зорилтын хүрээнд:** | | | | | | | |
| 15 | 7.1.1. Хөдлөх бүрэлдэхүүний дугаарын програм хангамжийг боловсруулах, хөгжүүлэх, турших, нэвтрүүлэх | 15.0 | Боловсруулалтын явц, хувиар | Шинээр хэрэгжүүлнэ | I | Хөдлөх бүрэлдэхүүний дугаарын хяналтын оронг тооцоолох програм хангамжийн хэрэглэгчийн интерфэйс, талбар, өгөгдлийг боловсруулна | ГХБАБМХ |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | II | Програм хангамжийн тооцоолох, давхцал шалгах үйлдлийг автоматжуулж хөгжүүлнэ | |
| | | | | | III-IV | Програм хангамжийн хэвийн үйл ажиллагааг хянах, шалгах, турших, сайжруулах арга хэмжээ авч програм хангамжийг нэвтрүүлнэ | |
| 16 | 7.1.2. Төмөр замын тээврийн салбарын томоохон дэд бүтэц эзэмшигч нарын салбар замуудын бүртгэлийн сан үүсгэх, бүрдүүлэх, хөтлөх | 5.0 | Боловсруулалтын явц, хувиар | Шинээр хэрэгжүүлнэ | I | "МТЗ" ТӨХК, "БТЕГ" ХХК-ийн салбар замын мэдээллийн сан үүсгэж цахимжуулна | ГХБАБМХ |
| | | | | | II | "УБТЗ" ХНН-ийн Баянтүмэн тасгийн салбар замын мэдээллийн сан үүсгэж цахимжуулна | |
| | | | | | III | "УБТЗ" ХНН-ийн салбар замын мэдээллийн сан үүсгэж цахимжуулна | |
| | | | | | IV | | |
| 17 | 7.1.3. Төрийн болон албаны нууцад хамаарахаас бусад мэдээ, баримт бичиг, албан хэрэг хөтлөлт, мэдээллийн системийн үйл ажиллагаанд тоон гарын үсгийн хэрэглээг нэвтрүүлэх, ашиглах цахимаар мэдээлэл солилцох | 4.0 | Боловсруулалтын явц, хувиар | Шинээр хэрэгжүүлнэ | I-IV | Зам, тээврийн хөгжлийн сайдын 2020 оны А/160 дугаар тушаалыг хэрэгжүүлж тоон гарын үсгийг нэвтрүүлж цахимаар мэдээлэл солилцоно | ГХБАБМХ ЗСХ |
| 18 | 7.1.4. Төмөр замын тээврийн салбарын хэмжээнд мөрдөгдөж буй стандартын цахим мэдээллийн сан бүрдүүлэх, хөтлөх | 5.0 | Хэрэгжилтийн явц, хувиар | Шинээр хэрэгжүүлнэ | III | Салбарын хэмжээнд мөрдөж буй стандартын мэдээллийн сан бүрдүүлнэ | ГХБАБМХ |
| | | | | | IV | Мэдээллийн сан үүсгэж, цахим хуудсанд байршуулж сурталчилна | |
| **8. Зам, тээврийн хөгжлийн сайдын 2021 оны А/01 дүгээр тушаал, Төвийн дүрмийн 4.3.5, 4.3.6, 4.3.13.** | | | | | | | |
| **8.1. Техник, технологи, судалгаа шинжилгээний ажлыг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд:** | | | | | | | |
| 19 | 8.1.1. Галт тэрэг найруулах төлөвлөгөөг цахим хэлбэрт шилжүүлэх, сэлгээний ажлын хяналтын автоматжуулсан системийн судалгаа боловсруулах | 10.0 | Боловсруулалтын явц, хувиар | Судалгааны ажлыг эхлүүлсэн | II | Судалгааг төслийн загварт оруулж шаардлагатай тооцоо судалгааг хийж гүйцэтгэсэн байна. | ТНУАСХ |
| | | | | | IV | Төсөлд ЗТХЯ, төмөр замын байгууллагаас санал авна | |
| 20 | 8.1.2. Галт тэрэгний зурмаг шинжилгээ, хяналтыг автоматжуулах системийн судалгаа, нэвтрүүлэлт | 30.0 | Боловсруулалтын явц, хувиар | Судалгааны ажлыг эхлүүлсэн | II | Япон улсын Жет Коннект компанийн санал болгож буй зурмаг шинжилгээний програм хангамжийг дэлгэрэнгүй судалж техникийн бичиг баримт боловсруулна | ТНУАСХ |
| | | | | | IV | Зөвлөх үйлчилгээнд шаардлагатай санхүүжилтийг шийдвэрлүүлэхээр ЗТХЯ болон олон улсын донор байгууллагатай хамтран ажиллаж, санхүүжилт авах боломжийг тодорхойлно | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 21 | 8.1.3. БНСУ-ЫН Койка ОУ-ын хамтын ажиллагааны нийгэмлэгтэй хамтран “Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төвийн барилга барих болон үйл ажиллагааны чадавхийг бэхжүүлэх замаар Монгол Улсын төмөр замын өрсөлдөх чадавхийг сайжруулах төсөл”-ийг хэрэгжүүлэхэд шаардлагатай арга хэмжээ авч ажиллах | --- | Боловсруулалтын явц, хувиар | Төслийн төлөвлөлтийн судалгаа хийгдсэн | I-IV | Цаг үеийн нөхцөл байдалд уялдуулан төслийн төлөвлөгөөний дагуу ажилласан байна. | ТНУАСХ |
| 22 | 8.1.4. Галт тэрэгний хөдөлгөөнийг удирдан зохицуулах радио зурвасыг хуваарилах, хяналт тавих, технологийн судалгаа хийх | 4.0 | Боловсруулалтын явц, хувиар | Шинээр хэрэгжүүлнэ | I | Төмөр замын хэрэглээнд радио давтамжийн зурвасыг төлөвлөх, хуваарилах, ашиглах журмыг батлана | ГХБАБМХ |
| | | | | | II | ХХЗХ-той хамтран галт тэрэгний хөдөлгөөнийг зохицуулах радио зурвасын ашиглалт, хуваарилалтад хяналт тавих бэлтгэл ажлыг хангана | |
| | | | | | III-IV | ХХЗХ-той хамтран галт тэрэгний хөдөлгөөнийг зохицуулах радио зурвас олгох, ашиглалт, хуваарилалтыг хэрэгжүүлнэ | |
| 23 | 8.1.5. Галт тэрэгний хөдөлгөөнтэй шууд холбоотой ажилтны сургалтын модуль /сургалтын танхим, бааз/ байгуулах судалгааны ажил боловсруулах | 3.0 | Боловсруулалтын явц, хувиар | Суурь судалгааг эхлүүлсэн | I | Хууль, эрх зүйн орчныг судална | ТНУАСХ |
| | | | | | II | Сургалтад ашиглагдаж байгаа симуляторын талаар судална | |
| | | | | | III | Сургалтын виртуал орчны талаар судална | |
| | | | | | IV | Судалгааны ажлын үр дүн, тайланг Захирлын зөвлөлийн хуралд танилцуулна | |
| **9.** | **Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль тогтоомж, ИрГУПС, ГТХЗНТ хооронд байгуулсан гэрээ, Төвийн дүрмийн 4.3.15, хөдөлмөрийн дотоод журам.** | | | | | | |
| **9.1.** | **Хүний нөөцийн удирдлагын манлайллаар хангах зорилтын хүрээнд:** | | | | | | |
| 24 | 9.1.1. Олон Улсын болон дотоодын сургалтын байгууллагатай хамтран салбарын инженерүүдийн мэргэжил дээшлүүлэх сургалтыг зохион байгуулах | --- | Сургалтад хамрагдах ажилтны тоо 10-15 | Магистрийн сургалтыг эхлүүлсэн | I | ИЗХУИС-тай хамтран зохион байгуулж буй сургалтын талаар салбарын байгууллагад сурталчилна. 2020 оны элсэгчдийн өвлийн сургалтын хичээлийг эхлүүлнэ | ТНУАСХ |
| | | | | | II | Магистрын сургалтад элсэгчдийн бүртгэлийн ажлыг зохион байгуулах. Суралцагчдын хаврын сургалтыг эхлүүлнэ | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | III | ИЗХУИС-тай хамтран зохион байгуулж буй сургалтын талаар видео контент хийж олон нийтэд сурталчилна | |
| | | | | | IV | Суралцагчдын намрын сургалтыг эхлүүлнэ | |
| 25 | 9.1.2. Хүний нөөц, хөдөлмөрийн харилцаатай холбоотой асуудлыг хууль тогтоомж, журмын хүрээнд шийдвэрлэх | --- | Хууль тогтоомжийн хүрээнд | Хэрэгжүүлж байна | I | Хүний нөөцийн хөтөлбөр, төлөвлөгөө, төсөл баталж хэрэгжүүлэх, удирдлага зохион байгуулалтаар хангана | ЗСХ |
| | | | | | II | Байгууллагын стратеги төлөвлөлт, гүйцэтгэлийн менежмент, мониторинг үнэлгээ хийх мэдлэг чадварыг нийт ажилтанд өгөх, хэрэгжүүлэх, төлөвшүүлэх ажлыг зохион байгуулна | |
| | | | | | III | Гүйцэтгэлийн удирдлагатай холбоотой дагаж мөрдөж буй эрх зүйн актыг боловсронгуй болгох талаар санал дүгнэлт гаргана | |
| | | | | | IV | Хүний нөөцийн эрэлт хэрэгцээг тодорхойлсны үндсэн дээр хүний нөөцийн дунд хугацааны төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлнэ | |
| **9.2. Хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах, хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулах, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, хяналт тавих зорилтын хүрээнд:** | | | | | | | |
| 26 | 9.2.1. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх | --- | Хууль тогтоомжийн хүрээнд | Хэрэгжүүлж байна | I-IV | ХАБЭА-н төлөвлөгөө боловсруулж батлан хэрэгжилтийг хангана | ЗСХ |
| | | | | | II | Ажлын тусгай хувцас, хэрэгслээр хангах, эрүүл мэндийн үзлэгт хамруулах, ажлын байрыг эрүүл ахуйн шаардлагад нийцүүлэх асуудлыг хөдөлмөрийн дотоод журам, хамтын гэрээнд тусгаж хэрэгжүүлнэ | |
| | | | | | III | Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийлгэнэ | |
| | | | | | IV | Эрсдэлээс хамгаалах, урьдчилан сэргийлэх, зөвлөн туслах үр нөлөөтэй механизмыг бий болгоно | |
| **10. Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 7 дугаар зүйлийн 7.1.1.** | | | | | | | |
| **10.1. Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах ажлыг зохион байгуулах зорилтын хүрээнд:** | | | | | | | |
| 27 | 10.1.1. ГТХЗНТ-ийн цахим хуудас, олон нийтийн сүлжээг хөгжүүлэх, хандалтыг нэмэгдүүлэх, хэвийн үйл ажиллагааг хангах, төмөр замын тээврийн үйл ажиллагаа, шинэ техник технологийг харуулсан видео контент бэлтгэх, мэргэжлийн байгууллагатай хамтран ажиллах | 6.5 | Контентын тоо 6 | Хэрэгжүүлж байна | I | Видео контент бэлтгэх талаар мэргэжлийн байгууллагаас сургалт авна | ТНУАСХ |
| | | | | | II | 2 контент бэлтгэж олон нийтийн сүлжээнд байршуулна | |
| | | | | | III | 2 контент бэлтгэж олон нийтийн сүлжээнд байршуулна | |
| | | | | | IV | 2 контент бэлтгэж олон нийтийн сүлжээнд байршуулна | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 28 | 10.1.2. Зам, тээврийн хөгжлийн яамны хэвлэл мэдээллийн төлөөлөгчтэй хамтран ажиллах, салбарын үйл ажиллагааг сурталчлах | 0.9 | Мэдээ, мэдээллийн тоо 12 | Хэрэгжүүлж байна | I<br>II<br>III<br>IV | Мэдээ, мэдээлэл нийтлүүлж үйл ажиллагаагаа сурталчилна | ТНУАСХ |
| 29 | 10.1.3. Төвийн сүлжээний рүүтэр төхөөрөмж, ажилтнуудын компьютерт шаардлагатай эд ангийг сольж шинэчлэх, хүчин чадлыг нэмэгдүүлэх, үйлдлийн системийг албан ёсны лицензээр баталгаажуулах | --- | Батлагдсан төсвийн хүрээнд | Шинээр хэрэгжүүлнэ | I | Сүлжээний рүүтэр төхөөрөмжийг шинэчилж, холболтын тохиргоо хийнэ | ГХБАБМХ |
| | | | | | II | Мэдээллийн аюулгүй байдлын талаар холбогдох журамд нэмэлт, өөрчлөлт оруулна | |
| | | | | | III-IV | Лицензтэй үйлдлийн систем, хэрэглээний програм хангамж, дотоод болон интернет сүлжээний хамгаалалтыг сайжруулах төхөөрөмжийн худалдан авалт хийнэ | |
| 30 | 10.1.4. Ил тод байдлын шалгуур үзүүлэлтийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, тайлагнах | --- | Шалгуур үзүүлэлтийн хэрэгжилт | Хэрэгжүүлж байна | II<br>IV | Үйл ажиллагаа, хүний нөөцийн ил тод байдлыг шалгуур үзүүлэлт тус бүрээр хангаж, цахим хуудас, мэдээллийн самбарт байршуулах, мэдээлэх, шинэчлэх, тайлагнах ажлыг зохион байгуулна | ТНУАСХ ЗСХ |
| **11. Төсвийн тухай хуулийн 7.4, 8.4.1, 8.8.1, 8.9.1, 16.5, 22.6.7, 41.2, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70.2, Шилэн дансны тухай хуулийн 3.1.1, 5.1.1, 6.1, 6.2, 6.3, 6.4, төвийн дүрмийн 5.1.2, 8.3, 8.4, 9, 10-р бүлэг.** | | | | | | | |
| **11.1. Төсвийн сар, улирлын хуваарийг баримталж ажиллах, батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайланг тогтоосон хугацаанд тайлагнах, эд хөрөнгийг зохистой ашиглах, эд хөрөнгийн тооллого, тооцоо бүртгэлийг чанартай хийх, тайлагнах зорилтын хүрээнд:** | | | | | | | |
| 31 | 11.1.1. Төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах | 708.1 | Төсвийн сар, улирлын хуваарь /зарцуу-лалт, Гүйцэтгэлээр/ | Хэрэгжүүлж байна | I | 2020 оны санхүүгийн үйл ажиллагааны тайланг төрийн аудитын байгууллагаар аудит хийлгэх, ТЕЗ-д хүргүүлэх, 2021 оны төсвийн гүйцэтгэлийг сараар, санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийг улирлаар тайлагнана | ЗСХ |
| | | | | | II | 2020 оны санхүүгийн аудитлагдсан тайланг шилэн дансны нэгдсэн портал, 2022 оны төсвийн төсөл, 2023-2024 оны төсвийн төсөөллийг ЗТХЯ-нд, төсвийн гүйцэтгэлийг сар бүр тайлагнана | |
| | | | | | III | 2021 оны эхний хагас жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан болон аудитын зөвлөмжийн биелэлтийг тайлагнаж,төсвийн гүйцэтгэлийн мэдээг сар бүр, 2022 оны төсвийн төсөл, 2023-2024 оны төсвийн төсөөллийг ЗТХЯ-нд хүргүүлнэ | |
| | | | | | IV | Төсвийн гүйцэтгэлийг сар бүр, 2020 оны III улирлын төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг хугацаанд нь тайлагнана | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 32 | 11.1.2. ГТХЗНТ-ийн үндсэн болон мөнгөн хөрөнгийн тооллого зохион байгуулах | --- | Тооллогын тоо 2 | Хэрэгжүүлж байна | II<br>IV | Тооллогын дүн, тайлан мэдээг танилцуулж өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад тооллого, бүртгэлээр хяналт тавина | ЗСХ |
| 33 | 11.1.3. Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэх | --- | Байршуул-бал зохих мэдээллийн тоо 151 | Хэрэгжүүлж байна | I-IV | Төсөв гүйцэтгэл, хөрөнгө оруулалт, тендэр, худалдан авалт, бусад төрлөөр шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээллийг хуулийн хугацаанд, иж бүрэн байршуулна | ЗСХ |
| **12. ЗТХЯ-ны албан хаагчдын нийгмийн баталгааг хангах хөтөлбөр** | | | | | | | |
| **12.1. ГТХЗНТ-ийн болон яам, харьяа байгууллагын албан хаагчдын орон сууцны барилгыг ашиглалтад оруулах зорилтын хүрээнд:** | | | | | | | |
| 34 | 12.1.1. ГТХЗНТ-ийн болон яам, харьяа газрын албан хаагчдын орон сууцны барилгыг ашиглалтад оруулах | --- | Барилгын ажлын явц, хувиар | Барилга угсралтын ажил 10 хувь | I | Санхүүжилтын асуудлаар хамтран ажиллах банкийг сонгож гэрээ байгуулна | "Ди Ди Эм Ти" ХХК, ЗСХ |
| | | | | | II-III | Барилгын ажлыг эхлүүлж, Захиалагчийн хяналт тавьж ажиллана | |
| | | | | | IV | Барилгыг ашиглалтад оруулна | |
| 35 | 12.1.2. ГТХЗНТ-ийн нөөц удирдлагын төв /backup/-ийн барилга баригдах газрын асуудлыг шийдвэрлүүлэх | --- | Шийдвэрлэлтийн явц, хувиар | Үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай тогтоол гарсан | I | Газар эзэмших эрхийн гэрчилгээг баталгаажуулж, архитектур төлөвлөлтийн даалгаврыг батлуулна | ЗСХ |
| | | | | | II- IV | Инженерийн шугам сүлжээний техникийн нөхцөлийг судалж, тодорхойлно | |
| **13. Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоол, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2017 оны 259 дүгээр тушаал** | | | | | | | |
| **13.1. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг хэрэгжүүлэх, биелэлтийг тайлагнах, ГТХЗНТ-ийн үйл ажиллагааны хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийх, үр дүнд нь үнэлгээ өгөх, эрсдэлийн удирдлагаар хангах** | | | | | | | |
| 36 | 13.1.1. Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, сайдын тушаал, сайдын шуурхай хуралдааны үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх, биелэлтийг тайлагнах | --- | Хэрэгжилтийн явц, хувиар | Төвийн үнэлгээгээр 95.8 хувь | I-IV | Хугацаанд нь хүргүүлж, ЗТХЯ-ны холбогдох газар, хэлтсийг мэдээллээр хангана | ЗСХ |
| 37 | 13.1.2. ГТХЗНТ-ийн үйл ажиллагааны явц, үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх | --- | ХШҮ-ний тайлангийн тоо 18 | Төвийн үнэлгээгээр 90.6 хувь | I-IV | Урьдчилан тодорхойлсон шалгуур үзүүлэлтийн дагуу хянан, мэдээлж төлөвлөсөн зорилтот түвшинд хүрсэн эсэхэд дүн шинжилгээ хийж үнэлэлт өгнө | ЗСХ |
| 38 | 13.1.3. Шинэ Налайх цэцэрлэгт хүрээлэнд "ГТХЗНТ" УТҮГ-ын нэрэмжит "инженер- ирээдүй" төгөл байгуулах | 1.0 | Хэрэгжилтийн явц, хувиар | Хэрэгжүүлж байна | II<br>IV | Тарьсан мод, бут, сөөгийг арчилж, шинээр мод тарина | ЗСХ |
| 39 | 13.1.4. Авлигын эсрэг хууль, нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан | --- | Сургалт, мэдээллийн арга хэмжээний тоо 4 | Хэрэгжүүлж байна | I-IV | Ажилтны ёс зүйн хэм хэмжээг чанд мөрдөж, авлига, ашиг сонирхлын зөрчил гаргахгүй, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг | ЗСХ |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийг хангах | | | | | сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийг чанд мөрдөнө | |
| 40 | 13.1.5. ГТХЗНТ-ийн хэмжээнд ажиллаж буй байнгын болон орон тооны бус комисс, зөвлөл, хороо, комиссын ажиллах чиглэлийг тодотгох, шинэчлэх, үйл ажиллагаанд нь хяналт тавьж, жигдрүүлэх арга хэмжээг зохион байгуулах | --- | Боловсруулалтын явц, хувиар | Хэрэгжүүлж байна | I-IV | Баталсан шийдвэрийн хэрэгжилтийг хангуулж, бүртгэл мэдээллийг боловсронгуй болгох, хийдэл зөрчлийг арилгах арга хэмжээг хэрэгжүүлнэ. Байнгын болон орон тооны бус комисс, зөвлөл, хороо, комисс нь ажлын төлөвлөгөөтэй, гүйцэтгэсэн ажлаа тодорхой хугацаанд тайлагнах үйл ажиллагаа тогтмолжино | ЗСХ |
| 41 | 13.1.6. Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчлэлт, хэрэгжилтийг хангахтай холбоотой судалгааны ажил зохион байгуулах | --- | Боловсруулалтын явц, хувиар | Шинээр хэрэгжүүлнэ | I-IV | Хуулийн төслийн 11 дүгээр зүйлд заасан 7 хэсэг, 23 заалт бүхий чиг үүргийг хэрэгжүүлэх төлөвлөлт, төсөөлөл, судалгааны ажлыг тухай бүр зохион байгуулна | ЗСХ<br>ТНУАСХ<br>ГХБАБМХ |
| 42 | 13.1.7. Олон Улсын хамтын ажиллагааг өргөжүүлэх үзэл баримтлалын баримт бичиг боловсруулах | --- | Боловсруулалтын явц, хувиар | Шинээр хэрэгжүүлнэ | I | Төмөр замын хамтын ажиллагааны байгууллага /ОСЖД/-тай хамтран ажиллах суурийг бэхжүүлнэ | ТНУАСХ |
| | | | | | II | Хөрш орнуудын төмөр замын байгууллагуудтай холбоо тогтоож хамтран ажиллах суурийг бэхжүүлнэ | |
| | | | | | III | Япон улсын Жет Коннект ХХК-тай хамтарсан ажлын хэсэг байгуулах хамтран ажиллана | |
| | | | | | IV | Хилийн боомтын өртөөдтэй хамтарч ажиллах суурийг бэхжүүлнэ | |

**Товчилсон үг:**

| | |
|---|---|
| ТЕЗ | -Төсвийн ерөнхийлөн захирагч |
| ЗТХЯ | -Зам, тээврийн хөгжлийн яам |
| ҮСХ | -Үндэсний статистикийн хороо |
| ХШҮДАГ | -Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар |
| ТНУАСХ | -Тээврийн нэгдсэн удирдлага, автоматжуулалт, судалгааны хэлтэс |
| ГХБАБМХ | -Гэрчилгээжүүлэлт, хөдлөх бүрэлдэхүүн ашиглалт, бүртгэл мэдээллийн хэлтэс |
| ЗСХ | -Захиргаа, санхүүгийн хэлтэс |
| ТЗТАБХЗОҮАГОЖ | -Төмөр замын тээврийн аюулгүй байдалтай холбоотой зарим обьект, үйл ажиллагаанд гэрчилгээ олгох журам |
| ТБОНӨХБАҮХАТХ | -Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль |
| ТЗДАБУЗСТХ | -Төмөр зам, далай ашиглалт ба усан замын стандартчиллын техникийн хороо |
| МАБ | -Мэдээллийн аюулгүй байдал |
| ХШҮ | -Хяналт-шинжилгээ, үнэлгээ |